



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/52

Мөрөн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын 2021 оны А/29 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Хөвсгөл аймаг дахь сонгогдсон байршилд 12 ширхэг нүхэн жорлонг стандартын дагуу шинээр барих арга хэмжээнд шаардагдах 38.800.000 (Гучин найман сая найман зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулах эрхийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т шилжүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулагдах 38.800.000 (Гучин найман сая найман зуун мянган) төгрөгийг холбогдох хууль журамд нийцүүлэн гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх, төлөвлөгдсөн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, тайлагнаж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Худалдан авах ажиллагаанд хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН